МЭДЭЭ · 2024 оны 11-р сарын 1

ТӨРД УЧИРСАН 144.9 САЯ ТӨГРӨГИЙН ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХЭЭР БОЛЖЭЭ



Дорнод аймгийн прокурорын газраас энэ оны эхний арван сарын байдлаар төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиг үүргийн хүрээнд 74 иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, төр нийтийн ашиг сонирхолд учирсан 144.9 сая төгрөгийг нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллажээ.

Тодруулбал, тус аймгийн хэмжээнд Засгийн газрын тусгай сангуудаас олгосон 74.8 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сан"- д учирсан 50.5 сая төгрөг, Гэмт хэрэг, зөрчлийн улмаас төр, нийтийн ашиг сонирхолд учирсан 19.6 сая төгрөгийн хохирол, нөхөн төлбөрийг төсөвт төвлөрүүлэхээр шийдвэрлүүлсэн байна.

Төр, нийтийн ашиг сонирхолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласны үр дүнд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцуулах төрийн байгууллагын хүсэлт нэмэгджээ.